



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/344

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/343 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлагнахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Баярмандал/, Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Мөнхтөр/ нарт тус тус даалгасугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Баасанпүрэв/-т үүрэг болгосугай.

САЙД



Ж.ГАНБААТАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн 11 дугаар тушаалын хавсралт 3

№	Төндөр шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журим, арга	Төндөр зарлах огноо	Тайлбар, тодруулга
III. Үндэсний геологийн алба								
1 Урсгал төсөв								
Хангамж бараа материалын зардал								
1.1		Бичиг хэрэг /бичгийн цаас/	Бараа	27,300.0	27,300.0	ХА	2024.01.22	
1.2		Тээвэр шатахуун	Бараа	11,371.6	11,371.6	ШХА	-	Тухай бүр худалдан авалт хийнэ.
1.3		Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	Бараа	15,585.2	15,585.2	ШХА	-	Тухай бүр худалдан авалт хийнэ.
1.4		Багаж, техник, хэрэгсэл	Бараа	47,250.0	47,250.0	НТШ	2024.03.20	
1.5		Хөдөлмөр хамгаалал	Бараа	3,238.8	3,238.8	ШХА	-	Тухай бүр худалдан авалт хийнэ.
1.6		Урсгал засвар	Ажил	50,000.0	50,000.0	ХА	2024.04.15	
Дүн				154,745.6	154,745.6			
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ								
1.7		Харуул хамгаалалт	ЗБУ	38,400.0	38,400.0	НТШ	2024.02.12	
1.8		Даатгалын үйлчилгээ	ЗБУ	6,075.1	6,075.1	ШХА	-	
1.9		Мэдээлэл технологийн үйлчилгээ	ЗБУ	80,845.1	80,845.1	НТШ	2024.02.19	
Дүн				125,320.2	125,320.2			
Урсгал төсвийн дүн				280,065.8	280,065.8			
2 Геологийн байгууллага								
2.1		Геологи хайгуулын судалгааны ажил	ЗУ	30,268,361.1	30,268,361.1	НТШ	2024.01.22	Эрх шилжиж ирсэн.
Дүн				30,268,361.1	30,268,361.1			
НИЙТ ДҮН				30,548,426.9	30,548,426.9			